



ЭРХИЙН МЭДЭГДЭЛ

**Урьдчилан хориход хоригдож буй
түргэвчилсэн хэлбэрийн шууд орох шүүх
хуралд орох хүнд олгох
эсвэл шүүхийн хяналтыг үгүйсгэсний дараагаар
протоколын дагуу шүүх хуралд орох**

Та засан хүмүүжүүлэх шүүхээр мөрдөгдөн шалгагдаж байгаа ба таныг буруутгаж буй хэргийг шүүн хэлэлцэх шүүх хурлын товлосон огноо хүртэл таныг урьдчилан хориход хоригдож байгаа болно. Уг баримт нь таны эдлэх гол эрхийг танд сануулж байгаа болно.

Та уг баримтыг урьдчилан хоригдож байгаа хугацаанд өөртөө хадгална

Гэмт үйлдлийн танилцуулга

Та өөрийн мөрдөгдөн шалгагдаж байгаа хэргийн зүйлчлэл, огноо ба газар байршлыг мэдэх эрхтэй ба мөн таныг урьдчилан хориход хоригдож байгаа шалтгаанаа мэдэх эрхтэй.

Өмгөөлөгчийн туслалцаа

Та өөрийн сонгосон өмгөөлөгч буюу улсаас томилдог үнэ төлбөргүй өмгөөлөгчийн туслалцааг авахаар хүсэлт гаргах эрхтэй.

Та өөрийн өмгөөлөгчтэй бичгээр буюу чөлөөтэй харилцах эрхтэй ба тэр таны шүүх хуралд дуудагдан, оролцоно.

Үг хэлэхгүй байх эрх

Шүүхийн өмнө та мэдүүлгээ өгөх, асуусан асуултуудад хариулах ба дуугаа хураан үг дуугарахгүй байх эрхтэй.

Хэлмэрчийн туслалцаа

Хэрэв та франц хэл ойлгодоггүй ба ярьдаггүй бол та байцаалтын үед өмгөөлөгчтэй ойлголцохын тулд үнэгүйгээр хэлмэрчийн туслалцаа авах эрхтэй.

Суллагдах хүсэлт гаргах эрх

Ямар ч үед та өөрийнхөө суллагдах талаар хүсэлт тавих эрхтэй.

Эрх чөлөө хасах хугацаа

Урьдчилан хориход хоригдож буй нь таны хурал болон засан хүмүүжүүлэх шүүхээр шинээр шүүгдэх огноо хүртэл үргэлжилнэ.

Хэрэв та Цагдан хорих болон суллах асуудлыг шийдвэрлэх эрх бүхий шүүгч шүүгчээр шүүгдэн урьдчилан хоригдож байгаа бол түргэвчилсэн хэлбэрийн шүүхээр шүүхийн өмнө хэргээ хэлэлцүүлэхэд, ажлын гурван хоногоос хэтрэхгүй байна.

Хэрэв та Цагдан хорих болон суллах асуудлыг шийдвэрлэх эрх бүхий шүүгч шүүгчээр

тогтоосон шүүхийн хяналтаа хүндэтгэж үзээгүй тохиолдолд уг хорио нь хоёр сараас илүү хугацаанд үргэлжилж болно.

Хэрэв та засан хүмүүжүүлэх шүүхээр мөрдөгдөн урьдчилан хориход хоригдож байгаа бол уг шүүхээс шүүх хурлыг хойшлуулсан бол, таны урьдчилан хорих зургаан долон хоногоос хэтрэхгүй бөгөөд эсвэл таныг буруутгаж буй хэрэг долоон жилээс дээш ял авахаар бол, уг хорио нь 4 сарын хугацаанд үргэлжилнэ.

Зарим нэгэн хүмүүст олгох мэдээлэл

Та өөрийн дурын болон ялангуяа өөрийн гэр бүлийн гишүүдэд урьдчилан хоригдож байгаа тухай мэдэгдэх эрхтэй.

Хэрэв та гадаад улсын иргэн бол өөрийн улсын консулын газарт мэдэгдэх эрхтэй.

Эмчийн үзлэг

Та эмчийн үзлэгээр орох хүсэлт гаргаж болно.

Таны хавтаст хэргийг үзэх

Таны өмгөөлөгч таны хавтаст хэрэгтэй танилцах ёстой ба түүний хуулбарыг авах хүсэлт гаргах эрхтэй. Та мөн адил хавтаст хэргийн хуулбарыг авах хүсэлт гаргах эрхтэй.